



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ”

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцоогүй, ЭЭС-ийн үйл ажиллагаа доголдолтой, эм зүйн салбарын хүний нөөц дутагдалтай, эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй байгаа нь бодлогын хэрэгжилт үр нөлөөгүй байгааг харуулж байна.”

АУДИТЫН КОД: ДУА-2021/14-11-ШТА-ГА

Тэргүүлэх аудиторовн үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох
Утас: 70592439,
Аудитын менежер Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Ихбаяр
Аудитор Д.Должинсүрэн
Аудитор Ж.Угтахбаяр
Утас: 70592208



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/36

Мандалговь

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 –д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2021/14-11-ШТА-ГА/ -г нэг дүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2022 оны 4 дугаар сарын 20-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга С.Од-Эрдэнэ, аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, Мэргэжлийн хяналтын газрын дарга Ш.Төрбат, Эрүүл мэндийн газрын дарга Б.Алтантөгс, Нэгдсэн эмнэлгийн дарга Х.Жаргал нарт зөвлөсүгэй.

4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2022 оны 1 дүгээр улиралд танилцуулахыг ахлах аудитор /Д.Ихбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Р.МӨНХТОГТОХ

0012010101

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	4
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
	Үндсэн мэдээлэл	7
	Дүрслэлийн товч	8
Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох	<u>Бүлэг А. Эрүүл мэндийн байгууллага эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангагдаж байгаа боловч ЭЭС-ийн үйл ажиллагаа доголдолтой, эм зүйн салбарын хүний нөөц дутагдалтай байна.</u>	9-17
Аудитын менежер Х.Наранцацрал	А.1 Эрүүл мэндийн байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах ажил үр дүнтэй байгаа боловч сумын хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангахад хүндрэлтэй байна.	8-13
	А.2 Эмийн хөнгөлөлтөд иргэд бүрэн хамрагдах боломж бүрдсэн байна.	13-14
Ахлах аудитор Д.Ихбаяр	А.3 Эрүүл мэндийн бодлого зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, эм зүйн салбарын хүний нөөц дутагдалтай байна.	15-17
Аудитор	<u>Бүлэг Б. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг гаргаж, дүгнээгүй, эмийн аюулгүй байдлын талаарх иргэдийн ойлголт дутмаг байна.</u>	18-22
Д.Должинсүрэн	Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг гаргаагүй, үнэлж, дүгнээгүй байна.	18-19
Ж.Угтахбаяр	Б.2 Эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээлэл иргэдэд дутмаг байна.	20-22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Дүгнэлт	23
	Зөвлөмж	24
	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	25-26
	Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар	27-28
ХАЯГ:		
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот		
2021 оны 11 дүгээр сар		

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЭМТББ	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
ТЭТББ	Төрөөс эмийн талаар баримтлах бодлого
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЧМҮАЭ	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХНБ	Эм ханган нийлүүлэх байгууллага
ЭЭЗХ	Эмийн эмчилгээг зохицуулах хороо
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ.

*Аудитын зорилго,
зорилт:*

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх
- ❖ Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөл буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Аудитад дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Гүйцэтгэлийн аудитын суурь зарчим;
- ✓ Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль;
- ✓ Эрүүл мэндийн тухай хууль;
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого” (Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоол)
- ✓ “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” (Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоол)
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Төлөвлөгөө батлах тухай” 425 дугаар тушаалаар баталсан “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;
- ✓ Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”
- ✓ Аудитын зорилго, зорилтод шаардагдах стандарт, бодлогын болон хууль эрх зүйн бусад баримт бичгүүд

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад төрөөс эмийн болон эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, эм эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний худалдан авалт, түгээлт, хяналтын талаарх төрийн зохицуулалт, хяналт шалгалтын тайлан, өгөгдсөн зөвлөмж, зайлшгүй шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн болон эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг баталсан шийдвэр болон бусад холбогдох материалыг ашигласан.

Тус аудитад Дундговь аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн даатгалын тасаг, Мэргэжлийн хяналтын газар, сумдын Эрүүл мэндийн төв, Эмийн эргэлтийн сангууд, эм хангамжийн байгууллагууд, хувийн эмийн сан болон бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан, аудитын арга зүйд тусгасан горим сорилыг хэрэгжүүлсэн.

Ковид-19 цар тахлын улмаас сумдад ажиллах боломжгүй байсан тул аймгийн Нэгдсэн эмнэлэг болон аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа Эмийн эргэлтийн сан, эм хангамжийн байгууллага, хувийн эмийн сан болон бусад холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцаж хууль, журам, стандартын хэрэгжилтийг шалгаж баримтжуулсан.

Аудитын асуудлын шинжилгээний 1 дүгээр бүлгийн 4 дэх түвшний А.1.1. дэх асуудлыг орон нутагт хамааралгүй гэж үзэн тайланд тусгаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандарт, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалд заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитын 3 дугаар нэгжийн ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн, Ж.Угтахбаяр нар 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Аудитын асуудлын шинжилгээнд 4 дэх түвшний асуултуудыг Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын заалтуудаар тавьсан, тийм/үгүй гэж задалсан асуултууд нь 4 дэх түвшний асуултыг дэмжихгүй байгаа зэрэг асуудлууд тулгарлаа.

Аудитын дүн

Тус аудитаар шалгагдагч байгууллагад зөрчил арилгуулах 2 албан шаардлага, ажил сайжруулах 11 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор 2014-2018 онд хэрэгжих Төрөөс эмийн талаар баримтлах бодлого (ТЭТББ) батлагдаж, бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь ЭМС-ын 2014 оны 425 дугаар тушаалаар тус тус батлагдсан байна.

Дундговь аймагт хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах эрх бүхий хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын дэргэдэх ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс олгож байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий нийтийн үйлчилгээтэй хувийн 9 эмийн сан, сумын 15 эм эргэлтийн сан, ЭХНБ 3, Нэгдсэн эмнэлэг, сумын төвийн 15 ЭМТ болон аймгийн төвийн ор бүхий 2 хувийн эмнэлэг, нийт 45 байгууллага үйл ажиллагаа явуулж байсан байна.

Хүснэгт №1 Эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилж буй байгууллагуудын жагсаалт

№	Хариуцлагын хэлбэр	2018	2019	2020
1	Хувийн эмийн сан	9	11	12
2	ЭЭС	15	15	15
3	ЭХНБ	3	3	3
4	Нэгдсэн эмнэлэг	1	1	1
5	Сумын ЭМТ	15	15	15
6	Хувийн ортой эмнэлэг	2	2	2
	Нийт	45	47	48

2020 оны байдлаар нийт байгууллагын тоо 48 болж, хувийн эмийн сан 3-аар нэмэгдэн тусгай зөвшөөрөл авсан байна.

Эдгээр 48 байгууллага нь эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандартаар эмийн сан болон мэргэжлийн боловсон хүчинтэй байхаар заасан байна.

Аймгийн хэмжээнд сумдын ЭМТ болон хувийн ортой эмнэлгүүд дээрх стандартын шаардлагыг хангаж ажиллахгүй байна.

Мөн Сумдын ЭЭС нь хөдөөгийн хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангах, сум, багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой байгууллага боловч сүүлийн жилүүдэд энэ байдал нь бүрэн хангагдаж ажиллахгүй байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж байна. 2018 онд сумдын ЭМТ болон Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах тендер шалгаруулалтыг Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан.

2019-2020 онд сумдын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах тендер шалгаруулалтыг аймгийн ЭМГ-т, Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах тендер шалгаруулалтыг Нэгдсэн эмнэлэгт эрхийг шилжүүлж, тухайн байгууллагууд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 2020 онд зарим эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээгээр худалдан авалт хийсэн байна.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт эмийн эмчилгээг зохицуулах 11 хүний бүрэлдэхүүнтэй хороо ажиллаж байна. Тус хороо нь дэргэдээ антибиотикийн дэд хороотойгоор эмийн чанар, аюулгүй байдал, эмийн хангалт, хэрэглээ, эмчийн жор бичилтэд хяналт тавих, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг журамд заасан бусад чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Амжилтгүй болсон тендер шалгаруулалт /2018-2020/	12
График 2	Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт /2018-2020/	13
График 3	МХТ-ын шалгалт	15
График 4	Энгийн жор бичилт хяналт	20
График 5	Хөнгөлөлт цахим жорын бичилт	20

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилж буй байгууллагуудын жагсаалт	7
Хүснэгт 2	2019-2020 оны эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт	12
Хүснэгт 3	Халамжийн сангаас олгосон тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ	14
Хүснэгт 4	Ёс зүй харилцаа, хандлагын сургалт	16
Хүснэгт 5	Эрүүл мэндийн салбарын эм зүйч, эм найруулагчийн судалгаа	17
Хүснэгт 6	Эмийн гэж нөлөөний бүртгэл	21

Зураглалын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	2018-2020 оны ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олголт	9
Зураглал 2	Эм эмнэлгийн хэрэгслийн 2018 оны худалдан авалт	11
Зураглал 3	2018-2020 онд хийсэн богино хугацааны сургалтын тайлан	16
Зураглал 4	“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг Дундговь аймаг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн үнэлгээ	19

БҮЛЭГ. 1

Эрүүл мэндийн байгууллага эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангагдаж байгаа боловч ЭЭС-ийн үйл ажиллагаа доголдолтой, эм зүйн салбарын хүний нөөц дутагдалтай байна.

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛЭЭР ТАСРАЛТГҮЙ ХАНГАХ АЖИЛ ҮР ДҮНТЭЙ БАЙГАА БОЛОВЧ СУМЫН ХҮН АМЫГ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМЭЭР ХАНГАХАД ХҮНДРЭЛТЭЙ БАЙНА.

1.1.1 Аймгийн Засаг даргын 2017 оны А/351 тоот захирамжаар ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталжээ. Гэвч комиссын бүрэлдэхүүнд хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын төлөөллийн оронд нэгдсэн эмнэлгийн чанарын албаны даргыг томилсон байна.


Нэгдсэн эмнэлгийн чанарын алба нь тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, арга зүйн дэмжлэг үзүүлдэг. Харин хувийн эмнэлэг, эмийн санд хяналт, шалгалт хийх чиг үүрэг байхгүй тул тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнд оруулах нь зохимжгүй юм.

Аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс нь 2018-2020 онд 4 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгож, 74 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

Харин тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, сэргээсэн, хассан тухай шийдвэр гаргаагүй байна.

Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/421 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2018-2020 онд баримтлах тэргүүлэх чиглэл”-тэй уялдуулан олгосон эсэхийг шалгахад шинээр олгосон 4 тусгай зөвшөөрлийн 3 нь тэргүүлэх чиглэлд ороогүй байна.

Зураглал №1 2018-2020 оны ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олголт



*Эх сурвалж: Аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комиссоос авсан судалгаа

Энэ нь Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 298 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах

журам”-ын 1.3¹, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”-ын 1.4.1², 1.4.2³-т заасан заалтуудыг зөрчсөн байна.

Хүчингүй болсон MNS 5260:2011 стандартын 5.5 дахь */Аймаг, нийслэлд эмийн сангийн тоог хүн амын нягтрал, болон байришлаас хамааруулан 5000 хүн ам тутамд 1 эмийн сан эсвэл эмийн сан хоорондын зай 500 метрээс багагүй байх/* заалтын дагуу эмийн сангийн тоог хязгаарлаж өгдөг байсан бол шинэчлэн баталсан стандартаар уг шалгуур хүчингүй болж, зөвхөн газар зүйн бүсчлэлээр зэрэглэл олгон, эмийн сангийн тоонд зөвхөн тэргүүлэх чиглэлээр хязгаар тавих боломжтой байна.

Аудитаар аймгийн төвийн нийтийн үйлчилгээтэй хувийн 9 эмийн сангийн үйл ажиллагаатай танилцахад аймгийн төвийн А бүсчлэлийн газарт хоёрдугаар зэрэглэлийн 3 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.

Энэ нь эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандартын 5.7⁴ -д заасныг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь аймгийн ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комисст хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас төлөөлөл оруулаагүй, тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгахдаа эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад хийсэн хяналт, шалгалтын мэдээллийг авч, харгалзан үздэггүй, хүсэлт гаргасан хуулийн этгээдийн ажлын байрны үнэлгээг тухайн газарт очиж, шалгадаггүй, мөн хууль, журмаа мөрддөггүйтэй холбоотой байна.

Иймд аймгийн Засаг даргад ЭМЧМҮАЭ тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнд журмын дагуу хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оруулж, комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн, дээрх зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлээ.



1.1.2 Манай улсад 1994-2004 оны хооронд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр 17 аймгийн 285 суманд ЭЭС-уудыг анх байгуулсан байна. Дундговь аймаг 2001 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 115 дугаар тогтоолоор 15 суманд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар буюу эм эргэлтийн санг байгуулах шийдвэр гарган, байгуулжээ.

Өнгөрсөн хугацаанд 15 сумын ихэнх ЭЭС-ийн үйл ажиллагаа нь доголдолтой, санхүүгийн тайлангийн харьцаа алдагдсан, алдагдалтай ажиллаж ирсэн байна. Энэ нь тухайн орон нутгийн ЭЭС-ийн зөвлөлийн үйл ажиллагаа, мэргэжлийн боловсон хүчний дутагдал, эмийн сангийн эрхлэгчийн идэвх санаачилга, санхүүгийн хяналт хангалтгүй, сумын хүн ам, алслагдсан байдал зэргээс шалтгаалж байна. Тухайлбал:

- Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумд өөрийн байргүй;
- Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Өндөршилээс бусад сумдын санхүүгийн тайлан алдагдалтай;
- Баянжаргалан, Хулд, Цагаандэлгэр, Дэрэн сумд мэргэжлийн хүн байхгүй;

¹ Комисс нь үйл ажиллагаандаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлээр тогтоосон зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална. Эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлийг үндэслэх

² Тусгай зөвшөөрөл хүсэгч нь эрүүл мэндийн салбарт баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцсэн төсөл боловсруулж ирүүлнэ

³ Тусгай зөвшөөрөл хүсэгчийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага байгуулах төслийн хэрэгцээ шаардлагад дор дурдсан хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ/ Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлага:

• Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй эсэх

⁴ Нийслэлийн болон аймгийн төвд газрын 1 дүгээр бүсчлэлд зөвхөн нэгдүгээр зэрэглэлийн эмийн сан байна.

- Баянжаргалан, Цагаандэлгэр, сумдын ЭЭС-ийн эрхлэгчийн ажлыг ЭМТ-ийн мэргэжлийн бус хүн давхар хариуцдаг;
- Адаацаг, Дэрэн, Луус, Өндөршил, Эрдэнэдалай сумдын ЭЭС-ийн эрхлэгчийг тэтгэврийн насны хүн хариуцдаг;
- Бүх сумд орон тооны нягтлан бодогчгүй;

Эдгээр асуудлууд нь хөдөөгийн хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангах, сум, багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл үүсгэж байна.

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2013 онд “Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудит”-аар ажил сайжруулах, 2015 онд “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит”-аар ЭЭС-ийн статусыг оновчтой байдлаар судалж шийдвэрлэх зөвлөмжүүдийг өгч байсан байна.

Мөн Эрүүл мэнд спортын яамны 2015 оны 1а/2642 тоот албан бичгээр ЭЭС-г сумын ЭМТ-д шилжүүлэх, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 1а/2179 тоот албан бичгээр ЭЭС-г хувьчлах нь зүйтэй гэсэн чиглэл, 2018 онд Эрүүл мэндийн яамны 7/153 тоот албан бичгээр удирдлагын зөвлөлийн хурлаас ЭЭС-г ЭМТ-д шилжүүлэх зөвлөмжүүд тус тус ирсэн байна.

Аймгийн ЭМГ-аас 2019 оны 01 сарын 10-ны өдрийн албан тоотоор ЭЭС-г сумдын ЭМТ-д шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг аймгийн ИТХ-д өгчээ.


Аймгийн ИТХ-аас Засаг даргад ЭЭС-ийн үйл ажиллагааг судлах үүрэг өгөгдсөнөөр сангийн бүтэц зохион байгуулалт үйл ажиллагааг судлах ажлын хэсэг байгуулагдан, Дорноговь аймгийн ЭЭС-ийн үйл ажиллагаатай танилцаж, судалгаа хийсэн боловч тодорхой шийдэлд хүрэлгүй хэвээр үлдээсэн байна.

Иймд Улсын хэмжээнд сумдын ЭЭС-ийн үйл ажиллагааг нэгдсэн журмаар судалж, орон нутгийн хувьд хамгийн зөв, оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлэх талаар ҮАГ-аар дамжуулан холбогдох байгууллагад санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.



1.1.3 Орон нутгийн өмчийн газраас 2018 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг, ЭМТ-үүдэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг нэгтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулжээ. Нийт 703.5 сая төгрөгийн 48 багц нээлттэй тендер шалгаруулалтаас 504.2 сая төгрөгийн 31 багц тендер амжилттай, 199.3 сая төгрөгийн 17 багц тендер амжилтгүй болж дахин зарласан боловч амжилтгүй болсон байна. *Зураглал № 2 Эм эмнэлгийн хэрэгслийн 2018 оны худалдан авалт*

Амжилтгүй болсон тендерийн 187.2 сая төгрөгийг шууд гэрээгээр, үлдсэн 12.1 сая төгрөгийг гэрээ байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна. Харин 2019 оноос ТБОНӨХБАҮХАТ хуулийн 4.1⁵, 4.1⁶ 45.1⁷-т



*Эх сурвалж: Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн худалдан авах ажиллагааны тайлан

⁵ Дараахь этгээд захиалагч байна:

⁶ төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;

⁷ Улсын болон орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалтаас бусад зардалд хуваарилсан хөрөнгө, бусад эх үүсвэр, түүнчлэн өөрийн

заасны дагуу сумдын ЭМТ-ийн эмийн тендер шалгаруулалтыг аймгийн ЭМГ-т, Нэгдсэн эмнэлгийн эмийн тендер шалгаруулалтыг Нэгдсэн эмнэлэгт эрхийг шилжүүлж, тухайн байгууллагууд өөрсдөө тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Эрхийг шилжүүлснээр амжилтгүй болсон тендерийн тоо 2019 онд 8 болж өмнөх онуудаас буурсан байна. Энэ нь төсөв захирагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь оновчтой байна. Харин 2020 онд амжилтгүй болсон тендерийн тоо өссөн нь цар тахлын үед эмийн тасалдал үүсэх эрсдэлийн улмаас эм ханган нийлүүлэгчид санал ирүүлээгүйтэй холбоотой байна.

График №1 Амжилтгүй болсон тендер



Аймгийн хэмжээнд нийт 2019 онд 814.1 сая төгрөгийн тендер зарлаж, байсан бол 2020 онд 758.0 сая төгрөг болж, 6.8 хувиар буурсан байна. Харин Нэгдсэн эмнэлгийн 2020 онд гэрээ байгуулалгүй шууд хийсэн худалдан авалт өмнөх оноос 5 хувиар 8.8 сая төгрөгөөр өссөн байна. Мөн 2019 онд шууд гэрээ байгуулсан худалдан авалтын 64 хувийг ЭМГ, 36 хувийг Нэгдсэн эзэлж байсан бол 2020 онд 35.6 хувийг ЭМГ, 64.4 хувийг Нэгдсэн эмнэлэг эзэлсэн байна

Нэгдсэн эмнэлэг 2020 онд “Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ” байгуулж 89.4 сая төгрөгийн 51 удаагийн гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн байна.

Хүснэгт № 2 2019-2020 оны эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт

Тендерийн нэр	Зарласан тендер		Шалгарсан тендер		Шууд гэрээ байгуулсан		Гэрээ байгуулаагүй	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл	623.8	634.4	564.6	542.9	41.9	65.4	17.3	26.1
Сумдын эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэл	190.3	123.6	115.7	87.4	74.6	36.2		
Нийт	814.1	758.0	680.4	630.3	116.5	101.6	17.3	26.1

*Эх сурвалж: Аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн худалдан авах ажиллагааны тайлан

Дээрх онуудад эмийн үнийн судалгааг сайн хийгээгүй, багцын хуваарилалтыг оновчтой хийгээгүй нь тендер амжилтгүй болох шалтгаан болсон байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4.1⁸-т заасныг зөрчиж байна. Иймд шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт хийж, багцын хуваарилалт оновчтой эсэх талаар судалгаа хийн, шийдвэрлэх шаардлагатай байна.

Мөн Нэгдсэн эмнэлэг 2018-2020 оны тендерийн гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн, харин ЭМГ 2020 оны тендерийн гэрээний хэрэгжилтийг ковид -19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан дүгнээгүй байна. Энэ нь ханган нийлүүлэгчидтэй байгуулсан “Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээ”-ний 9⁹-д заасныг зөрчиж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодис, дусал шингэний чанар, битүүмжлэл, тээвэрлэлт, ирүүлэх тоо хэмжээнд тавих хяналт сулрах эрсдэлийг бий болгож байна.

Иймд аудитын явцад гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулахын тулд 2 тал жилийн эцэст гэрээг дүгнэж холбогдох эрх зүйн актыг үйлдэж үр дүнг тооцож ажиллах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг захиалагч энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

⁸ Тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах

⁹ Жилийн эцэст 2 тал хамтран гэрээг дүгнэж эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийг хуваарь тооцон гаргаж акт үйлдэнэ



1.1.4 Эм, эмнэлгийн хэрэгслийн удирдлагын мэдээллийн системийг одоогоор орон нутгийн үйл ажиллагаанд нэвтрүүлээгүй. Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн систем болох www.licemed.mn цахим хуудсыг ашигладаггүй, эм, эмнэлгийн байгууллагууд болон иргэд олон нийт энэ системийн талаар мэдээлэл хангалтгүй байна.

Харин Нэгдсэн эмнэлгийн хувьд “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд www.eHealth.gov.mn, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд www.H-info.gov.mn статистикийн цахим программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан хөнгөлөлттэй жороор олгох эмийн www.health.gov.mn программыг сум, өрхийн ЭМТ-үүд, Нэгдсэн эмнэлэг болон хувийн эмийн сангууд, ЭЭС-ууд ашиглаж, хяналтыг ЭМД-ын тасагт хийж байна.


Эдгээр программууд нь хоорондоо уялдаа холбоогүй, мэдээлэл солилцох боломжгүйгээс ажлын ачааллыг нэмэгдүүлж, хяналт тавих нөхцөл, боломжийг бүрдүүлэхгүй байна.

Иймээс эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа дээрх программ хангамжуудын уялдаа холбоог сайжруулж хоорондоо мэдээллээ солилцох боломжийг бий болгон ажлын ачааллыг бууруулах арга замыг судалж эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх талаар ҮАГ-аар дамжуулан холбогдох байгууллагад санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.2 ЭМИЙН ХӨНГӨЛӨЛТӨД ИРГЭД БҮРЭН ХАМРАГДАХ БОЛОМЖ БҮРДСЭН БАЙНА.

1.2.1 Дундговь аймгийн Эрүүл мэндийн даатгалын тасаг 2018-2019 онд 20 эмийн сантай, 2020 онд 25 эмийн сантай “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г байгуулсан байна.

График №2 Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт



*Эх сурвалж: ЭМД-ын тасгаас авсан судалгаа

Хөнгөлөлттэй эмийн үйлчилгээний төлбөрт 2018 онд 516.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, 12,997 хүнд хөнгөлөлтөөр үйлчилсэн 20 эмийн санд 67.7 хувь буюу 350.3 сая төгрөгийн эмийн санхүүжилт олгосон байна. 2019 онд батлагдсан төсөв өмнөх оноос 3.4 хувь буюу 18.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 27,494 хүнд хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн 20 эмийн санд 444.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, өмнөх оноос 94.4 сая төгрөгөөр өссөн байна. Харин 2020 онд гэрээ хийсэн эмийн сангийн тоо 25 болон өсөж, батлагдсан төсөв 2019 оноос 13.5 хувиар буурсан байна.


Энэ нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт багассанаас шалтгаалжээ.

Хөнгөлөлттэй эмийн үйлчилгээний гүйцэтгэл 2020 онд хамгийн өндөр буюу 90.5 хувьтай байгаа нь гэрээ хийсэн эмийн сангийн тоо өссөнтэй холбоотой байна. Мөн эмийн санд олгох санхүүжилтийн гүйцэтгэл 100 хувьд хүрдэггүй байна.

Энэ нь шаардлага хангасан эмийн сангуудад тодорхой хэмжээний лимит тогтоон, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулдаг боловч зарим эмийн сангийн байршлаас шалтгаалан лимит нь бүрэн дуусдаггүйтэй холбоотой байна.

Харин 2021 оноос эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмийн үйлчилгээнд төсөв батлахаа больж, бүх эмийн сангуудтай хөнгөлөлттэй эм олгох гэрээ байгуулан,

санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгож байна. Энэ нь иргэд аль ч эмийн сангаар хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэх боломжийг бий болгожээ.



1.2.2 Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажилладаг боловч үйлчилгээ үзүүлээгүй, сангаас өндөр өртөгтэй эм эмнэлгийн хэрэгслийн санхүүжилт аваагүй байна. Энэ нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт одоогоор өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл, боломж бүрдээгүй байгаатай холбоотой байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай иргэд өөрийн зардлаар Улаанбаатар хотын улсын төв эмнэлгүүдээс өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч, халамжийн сангаас олгогдох эмнэлгийн хэрэгслийн хөнгөлөлтөд хамрагдсан байна.

Аймгийн ХХҮГ-аас 2018-2020 онд иргэдээс нэхэмжилсэн нийт 238.7 сая төгрөгийн өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн зардлын санхүүжилтийг олгожээ. Үүнд: Хиймэл түнхний үе солих хөнгөлөлтөд 11 хүнд 60.0 сая төгрөг, хиймэл өвдөгний үе солих хөнгөлөлтөд 26 хүнд 156.0 сая төгрөг, нүдний хатуу, зөөлөн уян болор солих хөнгөлөлтөд 106 хүнд 48.7 сая төгрөгийг журмын дагуу олгосон байна.

Судалгаанаас харахад эмнэлгийн хэрэгслийн санхүүжилтэд цөөн хүн хамрагдаж байгаа бөгөөд энэ нь өндөр өртөгтэй мэс засал цөөн хийгддэг, мөн зарим иргэд мэдээлэл дутмаг байдагтай холбоотой байна. 2021 оноос халамжийн сангаас олгогдох өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зохицуулалттай болсон байна. *Хүснэгт №3 /Халамжийн сангаас олгосон тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ/*

Үзүүлэлт	2018 он		2019 он		2020 он	
	Хүний тоо	Хөнгөлөлтийн дүн /сая төгрөг/	Хүний тоо	Хөнгөлөлтийн дүн /сая төгрөг/	Хүний тоо	Хөнгөлөлтийн дүн /сая төгрөг/
Хиймэл түнхний үед	3	18.0	5	24.0	3	18.0
Хиймэл өвдөгний үед	8	40.0	9	45.0	9	45.0
Нүдний уян болор /хатуу, зөөлөн/	43	19.8	29	13.3	34	15.6
Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд, ХБИ, ахмад настанд олгох /эм тарианавах/ тэтгэмж	785	385.5	860	452.1	957	658.3

*Эх сурвалж: ХХҮГ-аас ирүүлсэн судалгаа



Аймгийн ХХҮГ-аас аймаг, сумын амьжиргаа дэмжих зөвлөл Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын шалгуурыг хангасан байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд олгох эм тарианы тэтгэмжийг хянаж 2018 -2020 онд 2602 иргэнд 1,495.9 сая төгрөгийн тэтгэмжийг төрөөс олгосон байна. *Хүснэгт №3*

1.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО МУУ, ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ ДУТАГДАЛТАЙ БАЙНА.

1.3.1 Эмийн зохицуулалт, хяналтын чиг үүргийг аймгийн МХГ-ын эм био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч гүйцэтгэн 2018-2019 онуудад хяналт болон зөвлөн туслах чиглэлээр нийт 54 удаагийн хяналт, шалгалт хийжээ. Хяналтын хуудсаар дүгнэхэд 16 байгууллага бага, 22 байгууллага дунд, 1 байгууллага их эрсдэлтэй дүгнэгдсэн байна. Нийт шалгалтад хамрагдсан байгууллагаас 64.1%-ийг эмийн сан, 28.2%-ийг ЭМГ, 7.7%-ийг эм ханган нийлүүлэх байгууллага эзэлж байна. Шалгалтаар эмийг жоргүй олгосон, эмийн тунг буруу бичсэн, эмийн хэрэглэх зааврыг дутуу заадаг, гаргац муутай бичдэг, эмчийн тамга, гарын үсэг дутуу зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 313 заалт бүхий 36 албан шаардлага өгч ажилласнаар 2019 оны байдлаар зөрчил дутагдал буурсан байна. Харин 2020 онд хариуцсан мэргэжилтэн байхгүйгээс шалтгаалан хяналт шалгалт хийгдээгүй байна.

Мөн аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ЭМГ-аас эм, эмнэлгийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа, хууль, журам, стандартын мөрдөлтөд хяналтын чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын төлөөлөлтэй хамтран хяналт шалгалт зохион байгуулаагүй байна.

Мөн ЭМЧМУАЭ тусгай зөвшөөрөл олгох комисс нь МХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг харгалзан үзэхгүйгээр шийдвэр гаргаж байгаа нь төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа, холбоо байхгүй байгааг харуулж байна.

Энэ нь Нийгмийн бодлогын хэлтэс, ЭМГ-ын ажил хариуцсан холбогдох албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг^{10, 11}-тэй нийцэхгүй байгаа бөгөөд эмийн чанар аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээнд тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Иймд чиг үүрэг бүхий байгууллагууд харилцан уялдаатай, нэгдсэн зохицуулалттай хяналт шалгалтыг төлөвлөн гүйцэтгэж, үр дүнг тайлагнаж ажиллах нь зүйтэй байна.



1.3.2 Аймгийн ЭМГ-аас эм зүйн холбоо, мэргэжлийн нийгэмлэг, хувийн эмийн компаниуд, мэргэжлийн их дээд сургуулиудтай хамтран богино хугацааны багц сургалтын төлөвлөгөөг боловсруулан, эм зүйчийн 6 кредит, эм найруулагчийн 3 кредитийн сургалтыг жил бүр зохион байгуулсан байна.

График № 3 МХГ-ын шалгалт



¹⁰ Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагын бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хангуулах

¹¹ Эрүүл мэнд, хүн ам зүйн талаарх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нийгмийн бодлогын хэлтсийн даргын өмнө хариуцна.

Зураглал № 3 2018-2020 онд хийсэн богино хугацааны сургалтын тайлан



*Эх сурвалж: ЭМГ-ын 2018-2020 оны сургалт судалгааны тайлан

2018 онд орон нутагтаа 13 удаагийн сургалтыг 18 хоногт давхардсан тоогоор 1268 эмч, сувилагч, эм зүйч, эм найруулагч нарт амжилттай зохион байгуулжээ. 2019 онд орон нутагтаа 11, Улаанбаатарт 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 1127 хүн хамрагдаж, 2020 онд ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 3 удаагийн цахим сургалтыг амжилттай зохион байгуулж, давхардсан тоогоор 555 боловсон хүчнийг хамруулсан байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 446 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-ний хамрах хүрээ нь эм зүйн салбарын албан хаагчдад хамаарах эсэх нь тодорхой бус байсан бол 2019 оны А/406 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-д төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд хамаарна гэж тодорхой оруулж өгсөн байна.

Эрүүл мэндийн салбарын ажилтны ёс зүйн харилцаа, хандлагын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг жил бүрийн багц цагийн сургалтын төлөвлөгөөнд оруулан, сургалтыг жилдээ 2-5 удаа давхардсан тоогоор 280 – 621 албан хаагчдад зохион байгуулсан байна.

Хүснэгт №4 Ёс зүй харилцаа, хандлагын сургалт

№	Он	Хаана	Сургалтын тоо	Хамрагдсан хүн	Хугацаа / өдөр/
1	2018	Дундговь	2	280	3
	2019	Дундговь	5	504	5
2	2019	Улаанбаатар	1	7	1
3	2020	Цахим	4	621	4

Дэлхий нийтэд ковид-19 цар тахал гарснаар 2020 онд мэргэжлийн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлснээр сургалтад хамрагдсан хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

*Эх сурвалж: ЭМГ-ын 2018-2019 оны сургалт судалгааны тайлан

Дээрх сургалтуудын үр дүнд 2018-2020 оны хооронд эм зүйч болон эм найруулагчтай холбоотой ёс зүйн гомдол гараагүй байна.

Аймгийн Эрүүл мэндийн газарт эм зүйн мэргэшсэн хүний нөөцийн байршил хуваарилалтын төлөвлөгөө байхгүй бөгөөд зөвхөн үйл ажиллагаа явуулж байгаа эм хангамжийн байгууллага, эмийн сангуудын боловсон хүчний товч судалгаа байна.

Аймгийн Эрүүл мэндийн газарт 2018-2020 онд эм, эмнэлгийн хэрэгслийг хариуцсан хоёр мэргэжилтэн байсан бөгөөд 2021 оноос орон тоог багасган 1 мэргэжилтэн байхаар баталсан байна.

Энэ нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, эмийн чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж, түүний хяналт зохицуулалтын ажил цалгардах сөрөг үр дагавартай байна.

Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 4 төрлийн байгууллагад нийт 19 эм зүйч, 29 эм найруулагч ажиллаж байна.

Хүснэгт №5 Эрүүл мэндийн салбарын эм зүйч, эм найруулагчийн судалгаа

№	Хариуцлагын хэлбэр	Стандарт	2018		2019		2020	
			Байх ёстой	Байсан	Байх ёстой	Байсан	Байх ёстой	Байсан
1	Хувийн эмийн сан	2-3	21	21	26	25	31	28
2	ЭЭС /ОНӨААТҮГ/	2	30	10	30	11	30	12
3	ЭХНБ	2	6	5	6	4	6	4
4	Нэгдсэн эмнэлэг	6	6	3	6	3	6	4
5	Сумын ЭМТ	1	15	0	15	0	15	0
6	Хувийн ортой эмнэлэг	2	4	0	4	0	4	0
	Нийт дүн		82	39	87	43	92	48

*Эх сурвалж: Эмийн сангийн MNS 5260:2015 болон ЭМГ-аас авсан хүний нөөцийн судалгаа

Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандартын 6.1-д заасны дагуу эмийн үйл ажиллагаатай холбоотой 6 төрлийн хуулийн этгээдийн хүний нөөц, боловсон хүчний судалгааг стандарттай харьцуулахад аймгийн хэмжээнд 44 эм зүйч, эм найруулагч дутагдалтай байна. Үүнд:

- Хэвтэн эмчлүүлэх ор бүхий 2 хувийн эмнэлэг, бүх сумын ЭМТ-үүд мэргэжлийн эм зүйч, эм найруулагч байхгүй;
- Сумын ЭЭС-уудад 18, ЭХНБ 2, хувийн нийтийн эмийн сангуудад 3, Нэгдсэн эмнэлэгт 2 мэргэжлийн орон тоо дутуу;
- Баянжаргалан, Хулд, Цагаандэлгэр, Дэрэн сумдын ЭЭС-д мэргэжлийн бус хүн ажилладаг;
- Баянжаргалан, Цагаандэлгэр, сумдын ЭЭС-ийн эрхлэгчийн ажлыг ЭМТ-ийн ажилчид давхар гүйцэтгэдэг;
- Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрцогт, Өлзийт, Өндөршил, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдын ЭЭС-ийн эрхлэгчид сумын ЭМТ-дөө эм зүйчийн ажлыг хавсарч, цалин хөлс авдаг;

Хүний нөөцийн асуудал хамгийн дутагдалтай байгаа газар нь сумдын ЭМТ болон ЭЭС-ууд байна. Ялангуяа ЭЭС нь ОНӨААТҮГ учир цалин хөлс бага, орон нутгаас нийгмийн баталгааг нь хангах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс ажиллах эм зүйч, эм найруулагч олддоггүй байна.

Мөн хувийн нийтийн эмийн сангуудаас “Өсгө жирэм” эмийн сангийн эм зүйч, эм найруулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, “Онч”, “Мишээл” эмийн сангийн эрхлэгчид 3 жил ажиллаагүй эм зүйч ажиллуулж байгаа зөрчил илэрсэн. Дээрх зөрчлүүд нь MNS 5260:2011 стандартын 5.2¹², 6.3¹³-д заасныг зөрчсөн тул стандартыг хангуулахаар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт албан шаардлагыг хүргүүлээ

Дээрх асуудлууд нь аймаг, сумдын хүн амыг зайлшгүй шаардлагатай, чанартай, аюулгүй эмээр хангах үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл учирч, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө учирч болзошгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Иймд иргэдэд чанартай аюулгүй эмийг хүргэхийн тулд мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мөн давтан сургах асуудлыг орон нутгийн удирдлага болон харьяалах дээд байгууллагууд бодлогын түвшинд шийдвэрлэх шаардлагатай байна.

¹² Аймгийн төвийн эмийн сангийн эрхлэгч нь тухайн орон нутагт оршин сууж, тухайн эмийн санг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

¹³ Эм зүйч, эм найруулагч нь үндсэн ажиллаж буй эмийн сангаас гадна өөр эм хангамжийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа хавсран гүйцэтгэхгүй ба тухайн ажиллаж байгаа аж ахуйн нэгж нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

БҮЛЭГ. 2

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг гаргаж, дүгнээгүй, эмийн аюулгүй байдлын талаарх иргэдийн ойлголт дутмаг байна.

2.1. ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГААГҮЙ, ҮНЭЛЖ, ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.



2.1.1 Аймгийн ЭМГ-аас Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаагүй, бодлогын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж, хэрэгжилтийг тооцож, үр дүнг тайлагнаагүй байна. Аудитын явцад ЭМГ-аас тус бодлого нь **“2014-2018 онд хэрэгжиж дууссан”** гэсэн тайлбарыг өгсөн боловч бодлогын хэрэгжилт, тайлагналт, хяналт, үр дүнтэй холбоотой нотлох баримтыг ирүүлсэнгүй.

Энэ нь аймгийн ЭМГ-ын ажлын хариуцлагагүй байдал, Эрүүл мэндийн яамнаас бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг орон нутагт хэрхэн зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнах талаар тодорхой чиглэл заавар өгөөгүйтэй холбоотой байна.

Мөн Эрүүл мэндийн яамнаас бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг аймгийн ЭМГ-аас аваагүй, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг орхигдуулжээ.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2014 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан 2014-2018 онд хэрэгжих **“Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”** –ын баримт бичгийн 12 дугаар зүйл¹⁴, 12.1¹⁵, 12.2.¹⁶ дахь заалтыг манай аймагт хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

2.1.2 2017 онд Монгол Улсын ЗГ-ын 24 дүгээр тогтоолоор **“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”** батлагдаж, улмаар ЭМС –ын 2017 А/81 дүгээр тушаалаар ЭМС-ын 2014 оны **“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай”** 425 дугаар тушаалыг хүчингүй болгосон нь бодлогын хэрэгжилт, үр дүнг нь тооцох ажилд тодорхойгүй байдал үүсгэсэн байна.

Эрүүл мэндийн яам ЗГ-ын тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-ын тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичиг хүчингүй болоогүй байхад хэрэгжүүлэх төлөвлөгөөг нь хүчингүй болгож байгаа нь төр засгийн бодлого шийдвэрүүд хоорондоо уялдаа холбоо байхгүй байгааг харуулж байна.

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” –ын баримт бичигт **“Эм зүйн тусламж үйлчилгээ”**- ний чиглэлээр хэрэгжүүлэх 9 заалт тусгагдсан бөгөөд бодлогыг аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 2017 оны 218 дугаар захирамжаар батлан, **“Эм зүйн тусламж үйлчилгээ”**- ний чиглэлээр аймагт хамааралтай 5 заалтыг хэрэгжүүлж байна.

Гэвч аймгийн ЭМГ нь дэд хөтөлбөрийн 2017, 2018 оны хэрэгжилтийг гаргаагүй, 2019, 2020 онд хэрэгжилтийг гарган биелэлтийг тооцсон боловч бодлогын хэрэгжилтийн явцад АЗДТГ-ын

¹⁴ Хяналт үнэлгээ


¹⁵ Эрүүл мэндийн болон хөдөө аж ахуй асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн болон салбарын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

¹⁶ Орон нутгийн өмчийн алба нь бодлогын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээр хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй байна.

Зураглал № 4 “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг

Дундговь аймаг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн үнэлгээ



Мөн хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ-д танилцуулж цаашид анхаарах ажлуудыг тодорхойлон, дараа жилүүдийн төлөвлөгөөнд тусгах ажил огт хийгдээгүй байна.

Энэ нь дэд хөтөлбөрт тусгагдсан заалтуудын хэрэгжилт бүрэн хангагдахгүй, бодлогын хэрэгжилтийн явц үр дүн, үр нөлөө тооцогдохгүй, удирдлагыг мэдээллээр хангах боломжгүй болох үр дагавартай байна.

Иймд “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын дэд хөтөлбөр”- ийн 6.1¹⁷, 6.2¹⁸, 6.3¹⁹ -д заасны дагуу хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж, сайжруулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2018 онд аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдсэн “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар ТЭМТББ-ыг Дундговь аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн 2017, 2018 оны хэрэгжилтийг тооцож, үр дүнд шинжилгээ хийгээгүй зөрчилд зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

¹⁷ Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрүүл мэндийн газар нь жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 2 жил тутамд Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсээр үнэлгээ хийлгэнэ.

¹⁸ Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийгдэх хяналт-шинжилгээг Монгол улсын ЗГ-ын тогтоол /2013 оны 322-р тогтоол/-оор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд үндэслэн, боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулсан журмыг мөрдөх бөгөөд түүнд тусгагдсан арга зүйг ашиглана. Хяналт-шинжилгээ, үнэлгээ тасралтгүй явагдана.

¹⁹ Аймгийн Эрүүл мэндийн газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн болон шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг гаргаж, хэрэгжилт үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын хуралдаанд танилцуулна.


2.2 ЭМИЙН ГАЖ НӨЛӨӨГ БҮРТГҮҮЛЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ИРГЭДЭД ДУТМАГ БАЙНА.

2.2.1 МХГ-аас 2018, 2019 онуудад эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартын хэрэгжилтэнд хяналт хийж, ажилласан байна. Хяналтаар антибиотик эмийг эмчийн жоргүй олгосон, эмийн тунг буруу бичсэн, эмийн хэрэглэх зааврыг дутуу заадаг, гаргац муутай бичдэг, эмчийн тамга, гарын үсэг дутуу зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн байна.

Харин энгийн жорыг хангалтгүй бичиж байгаа нь Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016 стандартын 6.1²⁰-т зөрчсөн байна.

Сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах эмийн жорыг ЭМГ-аас олгосон маягтын дагуу бичин олгож байна. Эмийн сангууд сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах эмийг жорын дагуу иргэдэд олгон улирал бүр цагдаагийн байгууллагад тайлагнадаг байна.

График № 4




Нэгдсэн эмнэлгийн клиникийн эм зүйч энгийн жор бичилтэд хяналт тавьж үр дүнг нэгтгэж, ажилладаг байна. Үүнийг График № 3 -аар харуулбал:

2018-2020 онуудад нийт 1846 жор бичсэнээс 1317 жорын бичилтэд хяналт тавьж жор бичилтийн дундаж үнэлгээг 2018 онд 78 хувь, 2019 онд 82.5 хувь, 2020 онд 80.6 хувиар тус тус үнэлж баримтжуулжээ.

Эрүүл мэндийн даатгалын системд 2020.11.01-ний өдрөөс шинэчлэлт хийгдэж хөнгөлөлттэй эмийн цахим жороор олгох www.health.gov.mn программд нэвтрэх

эрхийг сум, өрхийн ЭМТ-үүд, Нэгдсэн эмнэлгийн нийт 134 эмчид нээж өгсөн байна. Үүнээс Нэгдсэн эмнэлгийн 18 эмчид цахим жор бичих эрхийг нээж өгсөн байна.

График №45 Хөнгөлөлт цахим жорын бичилт



Аудитын явцад хөнгөлөлттэй эмийн цахим жор олголтын 1, 2, 8, 9-р сарыг түүвэрлэн хяналт тавихад Сайнцагаан сумын ЭМТ болон Өлзийт мандал өрхийн ЭМТ-үүд хамгийн өндөр буюу 32-37 хувьтай байна. Харин Нэгдсэн эмнэлэг хамгийн бага буюу 12 хувьтай байгаа нь цахим жор бичилт хангалтгүй байгааг харуулж байна. Цахим жор бичих эрх авсан 18 эмчээс 7 эмч огт цахим жор бичээгүй, жор бичсэн 11 эмчийн 3 эмч нь нийт бичигдсэн жорын 68.0 хувийг нь бичсэн байна. Энэ нь Нэгдсэн эмнэлгийн эмч нар цахим жорыг харилцан адилгүй бичиж ажлын хариуцлагаас зугтах, иргэдэд чирэгдэл учруулж бусад өрхийн эмнэлгүүдэд ачаалал үүсгэж байна. Иймд хөнгөлөлттэй эмийн жорыг тогтмол бичиж хэвших, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

²⁰ Эмчлэх эрх бүхий хүний их эмч энгийн, сэтгэцэд нөлөөт, мансууруулах болон эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийг, бага эмч энгийн эмийн жорыг өвчтөний оношийн дагуу, энэхүү стандартыг баримтлан стандартад заасан жорын маягтад эсвэл цахимаар бичнэ



2.2.2 Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1²¹, ЭМС-ын 2019 оны А/414 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны ажиллах журмын 2.1.1²² заасны дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгт 11 хүний бүрэлдэхүүнтэй комисс ажиллаж байна.

Тус хороо нь дэргэдээ антибиотикийн дэд хороотойгоор эмийн чанар, аюулгүй байдал, эмийн хангалт, хэрэглээ, эмчийн жор бичилтэд хяналт тавих, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг журамд заасан бусад чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

ЭЭЗХ –нь үйл ажиллагааны тайлан мэдээгээ ЭМХТ болон ЭМГ –т хүргүүлж байгаа боловч ЭМХТ –өөс хяналт шалгалт хийж зөвлөмж чиглэл өгөгдөөгүй, аймгийн ЭМГ, ЭЭЗХ –ны эмийн хэрэглээний талаарх мэдээлэл болон ажлын тайлан мэдээг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлэх, дүн шинжилгээ хийж, арга зүй удирдлагаар хангах ажил хийгдээгүй байна.

Энэ нь ЭМС-ын 2019 оны А/414 дугаар тушаалаар батлагдсан “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-ны ажиллах журмын 5.3.²³, 6.1.²⁴ дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт №6 Эмийн гаж нөлөөний бүртгэл

2.2.3 Дундговь аймагт 2018-2020 онд нийт **29** эмийн гаж нөлөө бүртгэгдэж үүнээс Нэгдсэн эмнэлгийн ЭЭЗХ 28 иргэнд тохиолдсон эмийн гаж нөлөөг бүртгэн үнэлж ЭМЯ-ны Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн байна. Хүснэгт №1

Дээрх онуудад Нэгдсэн эмнэлгээс бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулж байгаа байгууллагуудад зөвхөн 1 эмийн гаж нөлөөний тохиолдол бүртгэгдэж байсан байна.

Он	Илэрсэн эмийн гаж нөлөө	Үүнээс			
		Байж болох	Үнэмшил- тэй	Илэр- хий	Эргэлзээ- тэй
Нэгдсэн эмнэлэг					
2018	6		5	1	
2019	6	4	2		
2020	16	11	5		
	28	15	12	1	
Эрүүл мэндийн газар					
2018	1		1		
Нийт	29	15	13	1	

*Эх сурвалж: Нэгдсэн эмнэлэг ЭЭЗХ-ны судалгаа



Аудитад хамрагдсан ЭМТ, орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн эмийн сангууд эмийн гаж нөлөөний мэдээллийг цуглуулах хайрцагт эмийн гаж нөлөөг мэдээлэх шар хуудас хийж харагдахуйц газар байрлуулсан боловч иргэдээс эмийн гаж нөлөөний мэдээлэл огт ирээгүй байсан.

Энэ нь иргэдийн эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөөний талаарх мэдлэг дутмаг, эрүүл мэндийн байгууллагууд гаж нөлөөний талаарх мэдээлэл сургалтыг эмнэлгийн мэргэжилтэн,

²¹ Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээний асуудлыг хариуцсан эмийн эмчилгээг зохицуулах хороо ажиллана.

²² Аймаг дүүргийн Нэгдсэн эмнэлэг, амаржих газарт эмчилгээ эрхэлсэн дарга, эмнэл зүйн эмч судлаач, эмнэл зүйн эм зүйчид, чанарын албаны дарга, сувилахуйн арга зүйч нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан зэрэг (7-оос доошгүй гишүүдээс бүрдэнэ)

²³ Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар нь эмийн эмчилгээг зохицуулах хорооны нэгтгэсэн дүнг, тайлангийн хамт Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

²⁴ Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах ажлыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүд хариуцан ажиллана.

иргэдийн дунд зохион байгуулах ажил хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд эмийн гаж нөлөөний улмаас эмчлүүлэгч хөгжлийн бэрхшээлтэй болох, төрөлхийн гажиг үүсэх, удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлэх, хөдөлмөрийн чадвар алдах эрсдэлтэй байна.

Нэгдсэн эмнэлгийн эм зүйч А.Үүрийнцолмонгийн говийн бүсийн аймгуудын эмийн гаж нөлөөний бүртгэл мэдээлэлд хийсэн судалгаагаар 2016-2018 онд манай аймаг нийт 23 буюу хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байсан байна. *Эх сурвалж : “Эмийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эм зүйчийн гүйцэтгэх оролцоо” сэдэвт Бидний алхам-2020 эрдэм шинжилгээний VI хурал –аас гарсан эмхэтгэл ном /*

Үүнээс 22 эмийн гаж нөлөө нь аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр бүртгэгдсэн эмийн гаж нөлөө байсан байна.

Иймд аймгийн ЭМГ-аас аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудад */Бүх зэрэглэлийн эмийн сан/* эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг эмнэлгийн мэргэжилтэн иргэдийн дунд тогтмол зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.2.4 Эрүүл мэндийн газраас 2018-2020 оны хооронд эм зүйн салбарын мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх эм зүйн удирдлага, зохион байгуулах чиглэлээр Эрүүл мэндийн газрын 2 мэргэжилтэн, нэгдсэн эмнэлгийн 1 эм зүйчийг мэргэжил дээшлүүлэх 4 сарын сургалтад төрийн сангийн зардлаар хамруулсан байна.

Харин Дундговь аймгийн нийтийн үйлчилгээтэй 24 эмийн сангийн эрхлэгч нараас эм зүйн албаны менежментээр мэргэшсэн хүн байхгүй байна.

Энэ нь MNS 5260:2015 стандартын 7.1²⁵-д заасныг зөрчсөн байна.

Мэргэшүүлэх сургалт нь цаг хугацааны хувьд урт байдаг тул орон нутгийн эмийн сангийн эрхлэгч нар Улаанбаатар хотод удаан хугацаагаар суралцах боломж муу байдагтай холбоотой байна. Иймд мэргэшүүлэх сургалтыг цахим орчинд зохион байгуулах боломжийг судлан шийдвэрлэх шаардлагатай байна.



²⁵ Эмийн сангийн эрхлэгч нь эм зүйн албаны менежментийн чиглэлээр мэргэшэх сургалтад хамрагдсан байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцоогүй, ЭЭС-ийн үйл ажиллагаа доголдолтой, эм зүйн салбарын хүний нөөц дутагдалтай, эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй байгаа нь бодлогын хэрэгжилт үр нөлөөгүй байгааг харуулж байна.”

1. 2018-2020 онд журам, стандартын шаардлага хангаагүй эмийн санд зөвшөөрөл олгосон байна.
2. Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт оновчтой бус, үйл ажиллагаа нь доголдолтой байна.
3. Зарим тендер шалгаруулалт амжилтгүй болсон ч хүн ам, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна.
4. Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа цахим программууд нь хоорондоо уялдаа холбоогүй, мэдээлэл солилцох, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлээгүй байна.
5. Иргэд аль ч эмийн сангаар хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэх боломжтой болсон байна.
6. Эрүүл мэндийн бодлого зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байна.
7. Эм зүйч, эм найруулагчийн богино хугацааны багц сургалтыг төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулсан байна.
8. Аймгийн хэмжээнд 44 эм зүйч, эм найруулагчийн орон дутагдалтай байна.
9. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад АЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээр хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй, аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ-д танилцуулаагүй байна.
10. Хөнгөлөлттэй эмийн цахим жорыг Нэгдсэн эмнэлгийн зарим эмч нар бичихгүй байна.
11. Эрүүл мэндийн газраас эмийн эмчилгээг зохицуулах хороог арга зүйн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.
12. Эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээлэл иргэдэд дутмаг байна.
13. Нийтийн үйлчилгээтэй 24 эмийн сангийн эрхлэгч нар эм зүйн албаны менежментээр мэргэшээгүй байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд;

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилттэй танилцан санал дүгнэлт өгөх;
2. Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалтыг эдийн засгийн хувьд үр ашигтай оновчтой болгох асуудлыг орон нутгийн түвшинд хамгийн оновчтой байдлаар шийдвэрлэх;

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст;

1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах дэд хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д танилцуулах;
2. Сумдын ЭЭС-ийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг судалж орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлүүлэх;
3. Эрүүл мэндийн бодлого зохицуулалт, хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;
4. Аймгийн эм зүйн салбарын хэмжээнд дутагдалтай байгаа эм зүйч, эм найруулагчийн орон тоог нөхөн бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлага, их дээд сургууль болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
5. Хууль, журам, стандартын шаардлага хангасан эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байх;

Аймгийн Эрүүл мэндийн газарт;

1. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудад эмийн гаж нөлөөг бүртгүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллийг эм, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдийн дунд тогтмол зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах;
2. Нийтийн үйлчилгээтэй 24 эмийн сангийн эрхлэгч нар эм зүйн албаны менежментээр мэргэшүүлэх сургалтыг нэгдсэн журмаар зохион байгуулах;
3. Сумдын ЭМТ-үүд болон ЭЭЗХ-ны эмийн хэрэглээний талаарх мэдээлэл болон ажлын тайлан, мэдээг нэгтгэн ЭМХТ-д хүргүүлэн, дүн шинжилгээ хийж, ЭЭЗХ-г арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт;

1. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэх хөнгөлөлттэй эмийн цахим жорын бичилтийг эмч нараар тогтмол бичүүлж хэвшүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах.



Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

ҮАГ-аар дамжуулан Эрүүл мэндийн яаманд дараах зөвлөмжийг хүргүүлэх саналыг уламжилж байна. Үүнд:

Үндэслэл 1:

2013 оноос хойш Дундговь аймгийн 15 сумын ЭЭС-ийн үйл ажиллагаа нь доголдолтой, санхүүгийн тайлангийн харьцаа алдагдсан, алдагдалтай ажиллаж ирсэн. Энэ нь тухайн орон нутгийн ЭЭС-ийн зөвлөлийн үйл ажиллагаа, мэргэжлийн боловсон хүчний дутагдал, эмийн сангийн эрхлэгчийн идэвх санаачилга, санхүүгийн хяналт хангалтгүй, сумын хүн ам, алслагдсан байдал зэргээс шалтгаалж байна.

Эдгээр асуудлууд нь хөдөөгийн хүн амыг зайлшгүй шаардлагатай эмээр хангах, сум, багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламж, үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй хүргэхэд хүндрэл үүсгэж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 9-10, 15 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 1:

Улсын хэмжээнд сумдын ЭЭС-ийн үйл ажиллагааг нэгдсэн журмаар судалж, орон нутгийн хувьд хамгийн оновчтой бүтэц, зохион байгуулалтын гарц, шийдлийг олж, шийдвэрлэх;

Үндэслэл 2:

Нэгдсэн эмнэлгийн хувьд “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд www.eHealth.gov.mn, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүд www.H-info.gov.mn статистикийн цахим программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан хөнгөлөлттэй жороор олгох эмийн www.health.gov.mn программыг сум, өрхийн ЭМТ-үүд, Нэгдсэн эмнэлэг болон хувийн эмийн сангууд, ЭЭС-ууд ашиглаж, хяналтыг ЭМД-ын тасагт хийж байна.

Эдгээр программууд нь хоорондоо уялдаа холбоогүй, мэдээлэл солилцох боломжгүйгээс ажлын ачааллыг нэмэгдүүлж, хяналт тавих нөхцөл, боломжийг бүрдүүлэхгүй байна.

Санал 2:

Эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа дээрх программ хангамжуудын уялдаа холбоогүй сайжруулж, хоорондоо мэдээллээ солилцох боломжийг бий болгон, ажлын ачааллыг бууруулах арга замыг судалж эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх;

Үндэслэл 3:

Аймгийн Эрүүл мэндийн газарт 2018-2020 онд эм, эмнэлгийн хэрэгслийг хариуцсан хоёр мэргэжилтэн */Эмийн чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ хариуцсан 1 хүн , Эмийн хэрэгслийн хангамж тусгай зөвшөөрөл хариуцсан 1 хүн/* байсан бөгөөд 2021 оноос орон тоог багасган 1 мэргэжилтэн байхаар баталсан нь ажлын ачааллыг нэмэгдүүлж, эмийн чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ, эм эмнэлгийн хэрэгслийн хангамж, түүний хяналт зохицуулалтын ажил цалгардах сөрөг үр дагавартай байна.

Санал 3:

Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоонд эмийн чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ хариуцсан 1, эмийн хэрэгслийн хангамж тусгай зөвшөөрөл хариуцсан 1, нийт 2 орон тоогоор ажиллуулж, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх.



Шалгагдагч байгууллагаас ирсэн санал

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг дарга болон аймгийн Эрүүл мэндийн газарт танилцуулж санал тайлбарыг авлаа.

Дундговь аймгийн засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн санал, тайлбар

Санал 1

Тайлбар 1

Шалгагдагч
байгууллагаас
“Санал
тайлбар
байхгүй” гэсэн
хариу ирүүлсэн.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

48090 Дундговь аймаг, Сайнцагаан сум
Утас/факс: 70592494
Цахим хаяг: info@dundgov.gov.mn

2021.11.08 № 9/1544

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Тус газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-нд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА А.НАРАНТУЯА**



488211151

Дундговь аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн санал, тайлбарт өгөх Төрийн аудитын газрын тайлбар

Санал 2

Тайлбар 2

Шалгагдагч байгууллагын ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн “Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал” хэсэгт нэмж орууллаа.


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

48000 Дундговь аймаг, Сайнцагаан-уул, 7 дугаар баг
С.Булдмаажидийн эргэн дотор 1, 103 1007
Утас: 7065-3824
И-мэйл: итг.газар@dundgov.gov.mn

2021.11.04 643

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Ихбаяр
Саналыг хүлээн
гачаанд хүргэв
2/4

“Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд Эрүүл мэндийн газрын бүтэц орон тооны загвар баталсан Эрүүл мэндийн сайдын тушаалд эм, эмнэлгийн хэрэгслийг хариуцсан 1 мэргэжилтэн байхаар баталсан нь ажлын ачаалал, ажлын байрны тодорхойлолтын хувьд тохиромжгүй шийдвэр тул өөрчлөх саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  БАЛТАНТӨГС

